



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/223

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо"-той хамтран зохион байгуулах "Эрүүл мэндийн эрх зүй ба эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
08 өдрийн 1223 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ ЗҮЙ БА ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ”
сэдэвт хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт**

Үндэслэл:

Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, ёс зүйн түвшинг дээшлүүлэх явдал манай салбарын нэг чухал ажлын нэг юм. Иймээс монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо нь улсын хэмжээнд гишүүнчлэлтэй байгаа үндсэн нэгжийн ҮЭ-ийн хороодын захиалга болон өөрийн байгууллагын ажлын төлөвлөгөөний дагуу салбарын эмч, ажилтнууддаа ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээний доголдлыг арилгахад чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Зорилго:

Анагаах ухааны ёс зүйн орчин үеийн онол, арга зүй, практикийн асуудлаар мэдлэгийг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгчдийн хоорондын үйл ажиллагаанд тохиолддог эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн талаарх мэдлэгийг дээшлүүлж төлөвлүүлэх, тэдэнд Эрүүл мэндийн тухай хууль болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс зүй, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх гэх мэт мэдлэгийг цогцоор эзэмшүүлэх зорилготой.

1. Эрүүл мэндийн тухай хуулийн мэдлэг олгох
2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн орчин үеийн асуудал, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн талаар гадаад орны туршлага
3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүйн хэм хэмжээ, агуулга, ёс зүйн түгээмэл алдаа сургамж
4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцааны алдаа, давах туулах арга зам

Хамрагдах хүрээ: Эрүүл мэндийн салбарын ҮЭ-ийн гишүүн эмч, ажилтнуудад

Сургалтын агуулга: Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой үүсч гардаг хүндрэл бэрхшээлүүд, түүнийг хэрхэн даван туулах, эрүүл мэндийн тухай хууль болон бусад эрх зүйн мэдлэг, дадлага эзэмшүүлэх

Сургалтын арга зүй: Лекц, ярилцлага, хэсгийн ажил, бодлого бодох, сэргээх дасгалын чиглэлээр явагдана.

Багшлах бүрэлдэхүүн:

1	Багшын нэр	Албан байгууллага	Мэргэжил	Мэргэжлээрээ ажилласан жил	Сурган заах арга зүйн гэрчилгээ /үнэмлэхний дугаар
1	Б.Мягмар	МЭМАҮЭХ-ны дарга	Хөдөлмөрийн эдийн засагч, эдийн засгийн ухааны докторант	14 жил	Сургалтанд хамрагдсан
2	Ч.Нарантуяа	МЭМАҮЭХ-ны дэд дарга	Социологич, Хөдөлмөрийн эдийн засагч, МҮЭ-ийн багш арга зүйч, эдийн засгийн ухааны магистр	31 жил	Сургалтанд хамрагдсан
3	Д.Баярмаа	АШУҮИС-ийн АУС-ийн Ерөнхий мэргэжилтний суурь ур чадварын тэнхимийн багш,	Их эмч, Анагаах ухааны доктор	20 жил	Сургалтанд хамрагдсан
4	Л.Ширнэн	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн	Их эмч, анагаах ухааны магистр, удирдлагын тэргүүлэх	33 жил	Сургалтанд хамрагдсан
5	С.Гантуяа	НЭМХ-гийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга	Их эмч, анагаах ухааны магистр нийгмийн эрүүл мэндийн м	29 жил	Сургалтанд хамрагдсан
6.	Б.Цэвэлмаа	Мари Стопс ОУБ-ын Данида төслийн зөвлөх	Их эмч, Тархвар зүйн шинжлэх ухааны магистр	18 жил	Сургалтанд хамрагдсан
7.	Э.Ганбат	Өмгөөлөгч	Хүний их эмч, эрх зүйч, АУ-ны болон хууль зүйн ухааны магистр	26 жил	Сургалтанд хамрагдсан

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ ЗҮЙ БА ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ ” сургалтын
сэдэвчилсэн төлөвлөгөө**

Цаг	Хичээлийн сэдэв	Багшийн нэр	Сургалтын хэлбэр	Хугацаа (мин)
08.00-09.00	МЭМАҮЭХ-ны бодлого, үйл ажиллагаа, салбарын хамтын хэлэлцээрт тусгагдсан зарим асуудлууд	<i>Б.Мягмар</i>	Лекц	60
09.00-09.10	Асуулт хариулт, ярилцлага		Семинар	10
09.10-10.10	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ	<i>Д.Баярмаа</i>	Лекц	120
10.10-10.20	Асуулт хариулт, ярилцлага		Семинар	20
10.20-11.10	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлууд	<i>С.Гантуяа</i>	Лекц	120
11.10-11.20	Асуулт хариулт, ярилцлага		Семинар	20
11.20-12.20	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба мэдрэмж	<i>Л.Ширнэн</i>	Лекц	100
12.20-12.50	Төлөвлөлтийн удирдлага		Лекц	80
12.50-13.00	Асуулт хариулт, ярилцлага		Семинар	30
13.00-14.00	Их завсарлага			
14.00-14.40	Эрүүл мэндийн эрх зүйн асуудлууд	<i>Э.Ганбат</i>	Лекц	80
14.40-15.10	Эмчийн алдаа, эрх зүйн зөрчил		Лекц	60
15.10-15.30	Эмчийн алдаануудад дүн шинжилгээ хийх, арилгах арга замыг тодорхойлох		Дадлага	40
15.30-16.20	Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцааны соёл	<i>Б.Цэвэлмаа</i>	Лекц	100
16.20-16.30	Асуулт хариулт, ярилцлага		Семинар	20
16.30-17.20	Өөрчлөлтийн удирдлага	<i>Л.Ширнэн</i>	Лекц	100
17.20-18.00	Стресс, түүнийг багасгах, ажил амьдралын тэнцвэртэй байдал Байгууллагын соёл, ёс зүй	<i>Ч.Нарантуяа</i>	Лекц	80

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
08 өдрийн дугаар А/223 тушаалын хоёрдугаар хавсралт



**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ ЗҮЙ БА ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Цайны зардал			
	Цай /кофе/	400	400	160000
	Печень /вафель	400	1200	480000
	Нэг удаагийн аяга, халбага	400	50	20000
	Сальфетка	5	3000	15000
				675.000
2	Бичиг хэргийн зардал			
	Дэвтэр	200	1300	260000
	Үзэг	200	900	180000
	Хэвлэх олшруулах	1500	100	150000
	Бичгийн цаас	10	9500	95000
	Дасгалын цаас	1	20000	20000
	Ц/с үзэг	5	2000	10000
	Фломастер	10	2000	20000
	Гэрчилгээний үнэ	200	1200	240000
	Багшийн хөлс	8	30000	240000
	Өдрийн хоол	200	12000	2400000
	Хулдаасан хэвлэл	-	-	80000
	Заалны түрээс	-	-	600000
	Бусад зардал	-	-	30000
				4325000
				5.000.000

Хянасан:

Боловсруулсан:


О.Баярсайхан

Д.Гантуяа /Ахлах нягтлан бодогч/

О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/